

ОНГОН СУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
11 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

2022.11.29

Хавирга

Нэг. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:

Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Тамгын газар, төрийн удирдлагын ажлын чиглэлээр

Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас төсөвт байгууллагуудын 2022 оны үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж, жилийн эцсийн тайланг 15 чиглэлээр бэлтгэж байна.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд Хяналт шинжилгээ хийх ажлын хэсэг 11 дүгээр сарын 12-13-ны өдөр тус суманд ажиллаж 2022 оны үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, зөвлөн тусалсан.

Хоёр. Эдийн засаг төсөв санхүүгийн бодлогын хүрээнд:

Удирдлага мэдээллийн цахим сүлжээг ашиглан төсвийн байгууллагуудын төлбөр тооцоог өдөр тутам хийж гүйцэтгэн холбогдох тайлан мэдээнүүдийг тогтмол гарган өгч байна.

Нийгмийн даатгалын байцаагчтай тухай бүр тооцоо нийлж, өр авлагагүй ажилласан.

Сар бүрийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээ, төрийн сангийн мэдээ, өглөг авлагын мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж цахим сүлжээгээр дамжуулан төрийн сангийн хэлтэст өгсөн.

Гурав. Хууль эрхзүйн бодлогын хүрээнд

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийг орон нутагт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж, байгууллага, холбогдох мэргэжилтнүүдэд хүргэсэн.

Соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу сумын нутагт орших түүх соёлын үл хөдлөх дургалыг гэрээгээр хамгаалагчдын уулзалт хэлэлцүүлэгийг анх удаа зохион байгуулсан. Уулзалтанд 10 гэрээт хамгаалагч, багийн засаг дарга нар оролцож тэдэнд “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”, сумын нутагт орших түүх үл хөдлөх дурсгалын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн. Онгон суманд 18 түүх үл хөдлөх дурсгал байдаг ба тэдгээрийг гурвалсан гэрээ хийсэний үндсэн дээр 10 гэрээт хамгаалагчид хариуцуулж цаашид хамтран ажиллах, мэдээ мэдээлэл солилцож байхаар хэлэлцэж, гэрээт хамгаалагчдад БАТЛАМЖ олгож, соёлын төвийн үзвэр үйлчилгээнд үнэгүй хамрагдах ЭРХИЙН БИЧИГ гардуулсан.

Хилийн бүс, зурваст нутаглаж байгаа иргэдтэй гурвалсан гэрээ байгуулах ажлыг 11 дүгээр сарын 21-нд зохион байгуулсан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс СӨБ-ын хүүхдүүдийн дунд замын хөдөлгөөний “Ногоон гэрэл-Цагаан шугам” танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулсан.

Гурав. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

ИТХ-аас шатар сонирхогчдын ур чадварыг дээшлүүлэх, орон нутагт шатрын спортыг хөгжүүлэх, амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор УИХ-ын даргын ивээл дор Шатар сонирхогчдын сумын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулсан.

Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсэж хөгжсөний 30 жилийн ойд зориулсан спортын 3 төрөлт тэмцээнд 13 сумын нийт 156 баг тамирчид авхаалж самбай хурд хүчээ сорин өрсөлдснөөс багийн дүнгээр 3 дугаар байр эзэлсэн.

Дорнод аймгийн Халх гол сумын Ялалт музейн “Тэд бидний төлөө Бид тэдний төлөө” үзэсгэлэнг хамтран зохион байгуулж ЕБС-ийн ахлах ангийн сурагчид болон төрийн албан хаагчид, ахмадуудад үзүүлсэн./110 сурагч, 98 иргэд хамрагдсан/

“Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд “Ахмадаа дээдлэе” өдөрлөг зохион байгуулж, Угийн бичгийн сургалтыг өгч, сургалтыг бататгах үүднээс АХА тэмцээн зохион байгуулав.

Бүх нийтэд соёлын боловсрол олгох хөтөлбөрийн хүрээнд ЕБС-ийн 62 сурагчдад “Орон судлах танхим”-ыг үзүүлж, сумын түүх соёлын талаар мэдээлэл олгосон.

Ерөнхий боловсролын сургуулийн монгол хэлний танхимаас “Бийрийн бичлэг”-ийн дугуйлангийн сурагчдын бүтээлээр “Монгол бахархал”-ын өдрөөр үзэсгэлэн гаргасан.

“Монгол бахархалын өдөр”-ийн хүрээнд 11 дүгээр ангийн сурагчид санаачлан төрт ёсны үнэт өв, үнэдсний уламжлал, Эзэн Чингис хааны суу алдар, агуу их түүхэн үйл хэргийг алдаршуулах, мөнхжүүлэх “Чингис хааны түүхэн гавьяа”-г харуулсан видео контентийг бэлтгэн сургачдад хүргэсэн.

Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд Бид дээрэлхэлгүй Дэвжээ тэмцээнийг зохион байгуулсан.

“Өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершипийн боловсрол олгох” төслийн Pitch-4 болж НТБ-ын залуучуудын “Уран шаглаа” төсөл, 10 дугаар ангийн сурагчдын “Бүтээлч охид” багийн төсөл тус тус шалгарч, санхүүжилт авч үйл ажиллагаа явуулах боломж нээгдсэн.

ЕБС-ийн сурагчдын авьяас чадварыг нээж илрүүлэх соёлын боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Урлагийн наадам-2022” уралдааныг хамтран зохион байгууллаа. Наадам 7 төрлөөр 2 өдөр үргэлжилж 448 авьяаслаг сурагчид оролцсон.

Соёлын төвийн бүрэлдэхүүн Хилийн 3 дугаар заставт ажиллаж, хилчдэд урлагийн тоглолт, “Явуулын номын сан”-гаар үйлчилж, Угийн бичгийн сургалт зохион байгуулсан.

Сумын аварга шалгаруулах Сагсан бөмбөг, Гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулагдаж 35 баг тамирчил оролцсон.

Дорнод аймагт зохион байгуулагдсан “Ялалт- клубын нэрэмжит “Жудо” бөрийн тэмцээнд 12 дугаар ангийн 2 сурагч “Хүрэл” медаль хүртсэн амжилттай оролцов.

Хүүхдийн цэцэрлэг, соёлын төв хамтран шинээр ирсэн хүүхдийн номноос бүрдсэн “Ном ирлээ” явуулын номын сангийн арга хэмжээг зохион байгуулж, үлгэрийн ертөнцөөр аялуулав.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн “Явуулын амбулатори” ирж ажиллан алслагдсан хөдөөгийн хүн амд нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношлогоог хийсэн.

Дөрөв: Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд:

Сумын төвд гэрэлтүүлэг, зам засварын ажлыг хийж, шинээр 100 ш гэрлийг шинэчилж, бүрэн гэрэлтүүлэгтэй болсон.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авсан ариутгал, халдваргүйтгэлийн Дүк, 50 ковш автомашиныг гүйцэтгэгч компаниудаас хүлээн авсан.